

Доктор, профессор Б.Батчулуун

Улаанбаатар дахь АНУ-ийн  
монгол судлалын төвийн зөвлөх

## ЗҮЙ ЁСНЫ ТУХАЙ Ж.РАУЛСЫН ОНОЛ (ЭГАЛИТАРИ ЛИБЕРАЛИЗМ)

**Түлхүүр үг:** *Гипотетик гэрээ, эрх чөлөө ба тэгш ёс, үл мэдэхийн хаалт (veil of ignorance), уг байдал (original position), зүй ёс (justice), Раулсын хоёр зарчим.*

### Оршил

Зүй ёс гэдэг бол хуульт ёс, шударга ёс, хүн ёс зэргийг багтаасан улс төр, эрх зүй, ёс зүйн маш өргөн хүрээтэй ойлголт. Хамгийн товчоор хэлэх юм бол **нийгэм дэх зохистой байдлыг илэрхийлсэн** ойлголт. Тэгэхээр энэ ойлголтын өмнөөс нийгэм-улс төрийн байгууламжуудыг үнэлж болдог.

Зүй ёс гэсэн ойлголтыг янз бүрийн утгаар тайлбарлаж болдог. Эдийн засгийн утгаар ч ярьж болно, улс төрийн утгаар ч ярьж болно. Зарим ном зохиолд зүй ёсыг албан ба материаллаг гэж хоёр хуваасан байдаг. **Албан** гэдэг нь зүй ёсыг нийгэм дэх хууль дүрмээр баталгаажуулсныг хэлж байгаа бол **материаллаг** гэдэг нь эрх, сонголт, хэрэгцээ гэх мэт зүйлсээр нэрлэж байгаа юм. Бидний авч үзэх гэж буй Раулсын онол зүй ёсыг материаллаг талаас нь авч үзсэн байдаг. Зүй ёсыг албан утгаар нь авч үзсэн онол ч байдаг. Үүний жишээ гэвэл Нозикийн "Зүй ёсны гавьяатны загварыг" нэрлэж болно. Гэвч бид энд эгалитари либерализмын тухай онцлох ёстой тул энэ тухайд дэлгэрэнгүй авч үзэхээс түдгэлзье.

### Тэгш эрх, эрх чөлөө хоёрын харьцаа буюу асуудлын мөн чанар

Одоо Барууны ардчилалд тулгараад байгаа гол асуудал бол нийгэмд хуримтлагдсан үндэсний баялагийг хэрхэн зүй зохистой хуваарилах вэ? гэдэгт оршиж байна. Зарим нь хэт их баялаг эзэмшиж байхад, зарим нь тийм багахан зүйл эзэмшиж байгаа нь шударга, зүй ёсны зүйл мөн үү? Тэгвэл нөгөө талаас, зарим хүмүүс бусдаасаа илүү авьяаслаг, ухаантай, хөдөлмөрч атал **өөрөөсөө бага хөдөлмөрлөдөг, дутуу ухаан, авьяастай хүмүүстэй адилхан амьдарч, адил хөлс авах нь зөв юм гэж үздэг асуудал зүй ёсоор тавигдана.** Асуудал ингээд зогсдоггүй. Хүн өөрийнхөө ачаар бус **байгалиас** илүү ухаан, авьяас, хөдөлмөрлөх чадвар заяасны төлөө **нийгмээс** илүү зүйл авч байх нь зүй ёсны зүйл мөн үү, байгалиас надад хязгаарлагдмал чадвар заяасан нь миний буруу юм гэж үү гэсэн асуудлууд цаана цаанаасаа урган гардаг.

Тэгэхээр бид дээрх асуудлуудын аль нь зөв, зүй ёсных вэ гэдэг асуултанд хариулж, алийг нь дэмжих ёстойгоо илэрхийлэх хэрэгтэй болж байна. Бид ихэвчлэн зөн билгээрээ энэ хоёр хоёулаа шударга, зүй ёсонд таарч байна хэмээн хариулдаг. Гэтэл энэ хоёр нь яг эсрэг тэсрэг баримтлалууд юм. Либерал барууныхныг дэмжвэл **эрх чөлөөг тэгш ёсноос дээгүүр тавьж** нийгэм дэх баян, ядуугийн туйлшралыг зөвтгөнө. Эгалитари зүүнийхнийг дэмжвэл ухаантай, авьяаслаг, хөдөлмөрч хүмүүсийн эрх чөлөөнд харшилсан баримтлалыг дэмжих болно. Зүй ёсны **энэ парадоксыг хэрхэн шийдвэрлэх вэ?** гэдэг нь орчин үеийн Барууны нийгэм улс төрийн философийн гол асуудал болж тавигдсан. Энэ асуудлыг шийдвэрлэхэд Жон Раулсын 1971 онд хэвлүүлсэн "Зүй ёсны онол" хэмээх бүтээл онцгой байр эзэлдэг. Энэ бүтээлийн гол ач холбогдол нь **либерал ба эгалитари** үзэл санааг эвлэрүүлэхийг оролдсонд байгаа юм. Дашрамд хэлэхэд энэхүү бүтээл нь нийгмийн философийн салбарт сүүлийн тавин жилд гарсан хамгийн жинтэй бүтээлийн тоонд зүй ёсоор ордог.

### **Зүй ёсны онол ба түүний онолын уг сурвалжуудын**

#### **тухай товчхон**

Зүй ёсны тухай асуудлыг үе үеийн сэтгэгчид өөрсдийн сургаальд янз бүрээр тавьсаар ирсэн юм.


Платон: Төр, хувь хүн хоёр хоёул оюун ухаанд захирагдаж байвал зүй ёсоороо байна гэж үзсэн.

Милль: Хэдий чинээ олон хүн аз жаргалтай байна тэр нь зүй ёс юм гэж утилитари үзэл санаатайгаа холбон тайлбарласан.

Маркс: Хүмүүс чадварынхаа хэрээр авахаас, хэрэгцээнийхээ хэрээр авах рүү явж байгаа бол тэр нь зүй ёс гэв.

Тэгэхээр эндээс харахад асуудал их том өргөн хүрээтэй байгаа юм. Орчин үед зүй ёсны онолын том төлөөлөгчид Ж.Раулс, Р.Нозик хоёрыг тооцно. Гол бүтээлүүд нь "Зүй ёсны онол", "Анарх ёс, төр, утопи үзэл".

Дараах зурагнаас харахад Раулс зөвхөн либерал түүний дотор Локкын уламжлалыг дагаагүй юм. Тэр тэгш байдлын асуудал дээр нийгмийн зөрчлийн онолыг (Марксын социалист онолыг) ч дагасан байна. Түүний үзэж байснаар хувь хүний эрх чөлөө нийгмийн баялгийг тэгш хуваарилах явдалд таарч зохицож байх ёстой. Энэ бол зүй ёсны тухай Раулсийн онолын хамгийн ерөнхий утга юм. Одоо энэ онолын дотоод механизмыг авч үзье.



### “Үл мэдэхийн хаалт”

Раулс өөрийн хэрэглэж байсан энэ нэр томъёогоор дамжуулж өөрийн онолыг нээн ойлгож болно гэж үзэж байв.

Раулс “Үл мэдэхийн хаалтыг” хүн шударга байх гол нөхцөл гэж үзэв. Хэрэв хэн нэгэн хүн тухайлбал, саятан хүн байх юм бол эгалитари үзлийг таягдаж, либертари үзлийн төлөө саналаа өгнө. Харин хөрөнгө чинээгээрээ доод хэсэгт хамаарагддаг хүн байх юм бол эгалитари системийн төлөө байх нь мэдээж. Тэгвэл шинээр сонгосон системд тухайн хүн дээрх хоёр нөхцөл байдлын алинд нь байхаа мэдээгүй үед юуг, хэрхэн сонгох вэ? Өөрөөр хэлбэл аль талд нь зогсох вэ?

Энд нөхцөл байдал бялуугаа булаалдсан хоёр ховдог хүүтэй ухаантай эхийнхтэй төстэй байдалтай байдаг. Хоёр хүү болон либертари болон эгалитарчууд зөвхөн өөрсдөө хожиж, нөгөөдхөө хохироохын төлөө байна. Ийм нөхцөлд эх нэг хүүдээ уг бялууг хуваах эрх, нөгөө хүүдээ түүнээс сонголт хийх эрхийг өгөв. Энэ бол **шударга нөхцлийг** бүрдүүлж буй шийдвэр юм. Раулс эгалитари болон либертари үзэлтнүүдийн өмнө асуудлыг яг ингэж тавьсан юм. Тэгэхээр энд таах буюу гипотез гол зүйл болно. Раулс ийм таамаглалт /гипотетик/ нөхцөл байдлыг “уг байрлал” гэж нэрлэсэн. (Локк ийм нөхцөл байдлыг “уг байдал” гэж нэрлэсэн байдаг).

Дээр өгүүлснээс харахад хоёр хүү буюу хоёр хүчний (либертари ба эгалитари) сонголт хийж буй шалтгаан нь хувийн сонирхол байна. Раулс ийм